



## UNIT VOCABULARY PRACTICE

1 **5A GRAMMAR AND VOCABULARY** Match the sentences 1–8 with the sentences a–h.

- 1 ☐ Thalia is determined to always be first.
- 2 ☐ The students are curious about new things.
- 3 ☐ Ollie is really dedicated.
- 4 ☐ Tamara has real talent.
- 5 ☐ That's such an original and creative idea.
- 6 ☐ Jackie is mature for her age.
- 7 ☐ I know he's sharp.
- 8 ☐ He always takes great care with his homework.

- a She's very gifted.
- b He's very responsible about it.
- c She's very sensible.
- d She's competitive.
- e He mustn't become overconfident though.
- f They're eager to learn new information.
- g You're so inventive!
- h He's very hard-working and focused.

2 **5B VOCABULARY** Complete the sentences with one preposition in each gap.

- 1 I really hate that dance class, so I've decided to drop out of it.
- 2 Come on, concentrate! We have to get \_\_\_\_\_ to some studying.
- 3 Because she was ill for two weeks, Christie has fallen \_\_\_\_\_ with her school work.
- 4 Have you come \_\_\_\_\_ with any ideas?
- 5 When are you going to hand \_\_\_\_\_ your project?
- 6 I'm behind in Maths – I'll have to catch \_\_\_\_\_ on the work I've missed.
- 7 You're going to have to really pull your socks \_\_\_\_\_ if you want to pass the exam.

3 **Replace the underlined parts in each sentence with the phrasal verbs from the box.**

come up go over ~~keep up with~~ pick up put off put together

- 1 I've got too much work. How will I stay at the same level as my classmates?  
keep up with
- 2 We're going to do some research and create a presentation about tourism.
- 3 I hope I'll manage to learn a few phrases in German while I'm in Berlin.
- 4 I have to do this for tomorrow. I can't delay doing the work.
- 5 Will the topics from Unit 1 appear in the test?
- 6 I'm not sure I understand this. I'll read the main points again later.

4 **5E LISTENING AND VOCABULARY** Complete the sentences with one word in each gap.

- 1 My cousin is unemployed at the moment, so she's looking for a job.
- 2 I don't really want to work night s \_\_\_\_\_ – working at night is exhausting!
- 3 The d \_\_\_\_\_ for this project is next week, no later.
- 4 My sister only works p \_\_\_\_\_ – four hours a day – but my mum works f \_\_\_\_\_.
- 5 My work placement is only t \_\_\_\_\_; it isn't a p \_\_\_\_\_ job.
- 6 It's a terrible job with long hours and l \_\_\_\_\_ w \_\_\_\_\_. I really want to find something else where I can earn more money.
- 7 It takes Dad an hour to c \_\_\_\_\_ to the nearest big city every day. He also does extra work, and when he works o \_\_\_\_\_ he's often tired at the weekend.
- 8 Paul is an architect and he's s \_\_\_\_\_ which means he doesn't have a boss. The idea of f \_\_\_\_\_ work like that is interesting.

5 **5F READING AND VOCABULARY** Complete the text with one word in each gap.

## THE FUTURE OF WORK

It can be difficult to make predictions about how workplaces, working practices and jobs are going to change in the future.

It's possible that the future will bring better career <sup>1</sup>opportunities, but it's also possible that there will be fewer jobs and more <sup>2</sup>unemployment as people lose their jobs because of advances in technology.

Will job prospects be better for white or blue <sup>3</sup>collar workers? Manual jobs may be at <sup>4</sup>risk because of automation, but perhaps new technology will <sup>5</sup>bring new kinds of work. And what about the economic side of things? Poor working <sup>6</sup>conditions are hard to accept, but if the <sup>7</sup>cost is very low too, then people may refuse to do those jobs. How will they be able to afford to pay their rent, bills, and so on?

<sup>8</sup>Repetitive jobs where people do the same thing again and again can affect workers' physical and mental health. People who have to <sup>9</sup>process information all day in front of a computer and have no opportunity to <sup>10</sup>interact socially with colleagues will suffer too. So, will the world of work be a positive or negative place in the future? What's your view? Send us your comments.

6 **ON A HIGH NOTE** Write a short paragraph about the type of working conditions that you think are ideal for you. Think about hours, salary, type of job, type of employment (freelance or employed by a company).



**VIII АНГИ**  
ХОЁРДУГААР ДЭВТЭР

# БИЕИЙН ТАМИР

(СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХӨТӨЧ)

2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

## **II ХЭСЭГ**

### **СУДЛАХ АГУУЛГА**

Сагсан бөмбөгийн спортын үүсэл түүх, үндсэн техникүүд

### **ЭЗЭМШИХ ЧАДВАР**

- Залалтын техникийг эзэмших
- Шидэлтийн техникийг сурах
- Дамжуулалтын үндсэн техникт суралцах
- 3х3 сагсан бөмбөгийн дүрмийг эзэмших

### **ХӨТЛӨХ БАГШ НАРЫН МЭДЭЭЛЭЛ**

|              |                                                            |
|--------------|------------------------------------------------------------|
| М.Пүрэвсүрэн | утас 99190151 Цахим хаяг: olonlog.school@gmail.com         |
| Ж.Сугар      | утас 99133174 Цахим хаяг: sugarj0723@gmail.com             |
| Б.Тамир      | утас 99179935 Цахим хаяг: badrakhtamir125@gmail.com        |
| Б.Шинэбаяр   | утас 88544006 Цахим хаяг: badamsambuu.shinebayar@gmail.com |



## II ХЭСЭГ

### САГСАН БӨМБӨГ

Энэхүү спортыг АНУ-ын Массачусетс мужийн Спрингфильдийн Залуу Христчуудын Холбооны коллежийн биеийн тамирын багш **Жеймс Нейсмит** гэгч Канад эр анх зохиожээ. Сагсан бөмбөг мэндэлсэн өдөр бол **1891** оны 12-р сарын 21-ны маш хүйтэн өвлийн нэгэн өдөр байсан гэж түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Энэ спорт тоглоомын төрлийг зохиосон Ж.Нейсмит гэгч хүн чухамдаа хэн байв аа? Яагаад энэ спортыг зохиох болов гээд олон асуулт ундрал гарч байгаа юм



Ж.Нейсмит нь 1861 оны 11-р сарын 6-нд Канад улсын Алмонтед төрсөн. Түүний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг нэг зүйл бол “DUCK on the ROCK” гэдэг тоглоом байсан бөгөөд энэхүү тоглоом нь түүний нээсэн сагсан бөмбөгийн үүсэл хөгжилд нөлөөлхүйц учиртай байжээ.

Тус коллежийн биеийн тамирын хэлтсийн ахлах, нарийн бичгийн дарга доктор Лютер Хелси Гулик сэтгэл судлалын семинар дээр өвлийн улиралд битүү, хиймэл гэрэлтүүлэгтэй зааланд залуучуудын сонирхлыг татахуйц шинэ тоглоомын төрлийг сэдэж олохыг зөвлөсөн. Ингэж Гуликийн заавраар биеийн тамирын багш Жеймс Нейсмит 1891 оны өвөл тоглоомын шинэ төрлийг санаачилж “Сагсан бөмбөг”-ийг тоглоход амархан, харин сайн эзэмшихэд хэцүү гэж тодорхойлж байжээ. Ж.Нейсмитийн гавьяаг үнэлэн Спрингфилдийн коллеж 1911 онд “Биеийн тамирын хүндэт мастер”, 1936 онд Мак Гиллын Их сургууль “Анагаах ухааны доктор” цолоор тус тус шагнасан байна. 1968 онд Спрингфилдын коллежийн дэргэд Ж.Нейсмитийн музейг байгуулсан бөгөөд хожим нь “**Сагсан бөмбөгийн алдрын танхим**” гэж нэрлэгдэх болсон. Ингэж хүн төрөлхтөнд гайхамшигт сайхан тоглоомыг бэлэглэсэн энэ хүнийг мөнхжүүлэн хүндэтгэл илэрхийлсэн юм. Ж.Нейсмит 1861 онд Канад улсад төрөөд 1939 онд нас барсан. Мэдээж тоглоомын шинэ төрлийг сэдэж олохын тулд эрт дээр үед Америк тивд дэлгэрч байсан бөмбөгтэй тоглоомын түүхэн мэдээ баримтуудыг ашигласан нь ойлгомжтой. Жишээ нь одоогоос 2000 жилийн тэртээ Мексикийн нутаг дээр амьдарч байсан Инк Майя гэдэг овгийнхон “Пок-то-пок” бөмбөгтэй тоглоом тоглож байжээ. Тоглоомын гол зорилго нь эгц босоо хананд байрлуулсан чулуун цагирагт бөмбөгийг шидэж оруулах явдал байлаа. Мөн XVI зууны үед Ацтекууд “Олмалитули” нэртэй тоглоом каучукан бөмбөгөөр чулуун цагирагт шидэн тоглож байсан байна. Ж.Нейсмит заалын тагтан /балкон/ дээр жимсний 2 сагс байрлуулаад бөмбөг шидүүлдэг байсан. Гимнастикийн заалны тагтны өндөр 3 м 05 см байсан ба энэ хэмжээ одоо хүртэл сагсан бөмбөгийн цагирагийн өндөр болон хадгалагдсаар үлджээ. Бөмбөгийг сагсанд шидэж оруулж байсан учраас /Basket – сагс, ball-бөмбөг/ сагсан бөмбөг нэрийг олжээ. Ж.Нейсмит 1891 оны XII сард шинэ тоглоомынхоо дүрмийг бичиж анхныхаа тэмцээнийг зохион байгуулж, 1892 онд сагсан бөмбөгийн дүрмийн номоо хэвлүүлжээ.



Сагсан бөмбөгийн спорт нь манай улсад 1940 оны эцсээр хөгжиж эхэлсэн гэх боловч байр, талбай хэрэглэл материал дутагдалтай байсны дээр тухайн үед манай оронд уригдан ирж ажиллаж байсан Зөвлөлт холбоот улс, Хятадын мэргэжилтнүүд өөрсдийн чөлөөт цагаар тоглож тэднээс манай зарим залуучууд суралцан, 1946 онд анхны тэмцээнээ

зохиож байжээ. Харин одоо манай оронд сонирхогчдын болон мэргэжлийн гэсэн тодотголтой 10 гаруй лигийн тэмцээнүүд жилд зохион байгуулагдаж байна. Үүнд: Үндэсний Супер лиг, Гоё дээд лиг, 21 аймгийн үндэсний лиг, Спрайт супер лиг, MGL D лиг, MGL G лиг, Оюутны лиг, Friends лиг гэхчлэн олон лигүүд зохиогдож байна.

### Залалт


Залалт нь бөмбөгтэй тоглогчийн шилжих үндсэн арга хэлбэр юм. Бөмбөг залах нь довтлон тоглогчид талбайгаар шилжих боломжийг олгодог. Тоглолтын энэ арга барилыг



дутуу эзэмшвэл шидэлт, дамжуулалт гүйцэтгэх ашигтай байрлалд сугаран гарч чадахгүйгээс гадна хамгаалагчийн эсрэг үйл ажиллагаа явуулах бололцоогүй болно. Залалтын үед өрсөлдөгчдөө бөмбөгөө булаалгахуйн тулд харгалзагчаас хол талын гараар бөмбөгийг залж их бие, хөл, гараар хашсан байх ёстой.

### Дамжуулалт

Сагсан бөмбөгийн үндсэн техник арга барилуудын нэг бөгөөд түүний тусламжтайгаар тоглогчид хамтын үйл ажиллагаагаа явуулдаг. Сагсан бөмбөгт 20 гаруй төрлийн дамжуулалт байдаг ч тэдгээрийг тоглолтын нөхцөл байдалд тохируулан хэрэглэнэ. Дамжуулалт нь байрнаас ба хөдөлгөөн дунд, хол ойрын, шулуун ба тойрог, шаланд ойлттой гэсэн хэлбэрээр хийгддэг. Чиглэлээр нь талбайн дагуу, хөндлөн ба ташуу дамжуулалт гэж ангилна.



## Шидэлт

Цагирагт бөмбөг шидэх нь тоглолтын техникийн чухал элемент юм. Бөмбөгийг янз бүрийн байрлалаас цагирагт оновчтой шидэх чадварыг дасгал сургуулилтын явцад олж авдаг. Шидэлтийг оновчтой гүйцэтгэх үйлдэл нь тухайн тоглогчийн техник, арга барилыг оновчтой эзэмшсэн байдал, сэтгэл зүйн тогтворжилт мөн анхаарлын төвлөрөлт зэргээс ихээхэн шалтгаална.



## 3х3 сагсан бөмбөг

3х3 гудамжны сагсан бөмбөг нь олон жилийн турш дэлхийн маш олон орны гадаа талбайд тоглогдож ирсэн боловч албан ёсны болж чадаагүй байлаа. 1980 оны сүүл хэсгээс АНУ гудамжны сагсан бөмбөгийг стандартчилж эхэлсэн бөгөөд улс орон даяар тодорхой арга хэмжээнүүдийг зохиож, тоглогчдийг нээж эхлэв. 1992 онд Адидак компани нь албан ёсны тэмцээнүүдийг зохиох болсноор 3х3 сагсан бөмбөгийн хөгжил одоо хурдацтайгаар өсөж байна.

ФИБА анх 2007 онд Макаод болсон Азийн наадамд 3х3 сагсан бөмбөгийн төрлийг туршилтын журмаар оруулж мөн дараа нь 2008 оны 4-р сард Доминикан, 10-р сард нь Индонез улсад туршалтын арга хэмжээнүүд зохион байгуулсан юм. Хамгийн анхны албан ёсны том тэмцээн нь 2009 оны Азийн залуучуудын наадамд зохион байгуулагдаж эрэгтэй 19, эмэгтэй 16 баг өрсөлдсөн байна. Мөн 2010 онд Сингапурт зохиогдсон залуучуудын олимпийн наадамд үндсэн төрөлд багтсанаас хойш дэлхий улс бүхэн 3х3 сагсан бөмбөгөөр хичээллэж өндөр түвшинд хөгжүүлж байна. 3х3 сагсан бөмбөг нь 2020 оны зуны олимпийн наадамд албан ёсны төрөл болон орохоор болсон билээ.



АНГИ, БҮЛЭГ ....

СУРАГЧИЙН ОВОГ, НЭР: .....

**ДАСГАЛ ДААЛГАВАР**

1. Сагсан бөмбөгийн спорт хэдэн онд, аль улсад үүссэн бэ?  
.....
2. Сагсан бөмбөгт үндсэн хэдэн зогсолт байдаг вэ?  
A. 2                      B. 5                      C. 1                      D. 4
3. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо хэдэн онд байгуулагдсан бэ?  
A. 1920                  B. 1932                  C. 1935                  D. 1928
4. Сагсан бөмбөг хэдэн онд олимпийн наадмын хөтөлбөрт орж эхэлсэн бэ?  
A. 1928                  B. 1935                  C. 1925                  D. 1950
5. 1968 онд Спрингфилдын коллежийн дэргэд Ж.Нейсмийн музейг байгуулсан бөгөөд хожим нь “.....” гэж нэрлэгдэх болсон.  
A. Сагсан бөмбөгийн ордон                  B. Сагсан бөмбөгийн музей                  C. Сагсан бөмбөгийн сургууль  
D. Сагсан бөмбөгийн алдарын танхим
6. Сагсан бөмбөгийн шитний өндөр хэд вэ?  
A. 3м 05см              B. 2м 95 см              C. 3м 50см              D. 3м 10см
7. Сагсан бөмбөгийн анхны дэлхийн аварга багаар ямар улсын эрэгтэй, эмэгтэй багууд тодорсон бэ?  
A. Итали, Хорват  
B. ЗХУ, Америк  
C. Франц, Аргентин  
D. Аргентин, Америк
8. Сагсан бөмбөгт тоглолтын нөхцөл байдалд тохируулан хичнээн дамжуулалтыг хийх боломжтой вэ?  
A. 30-аас дээш              B. 10 орчим              C. 20 гаруй              D. 5-аас илүүгүй
9. Бөмбөгтэй тоглогчийн шилжилт хийх үндсэн арга юу вэ?  
A. Гүйх                      B. Үсрэлт                      C. Залалт                      D. Шидэлт
10. Бөмбөгийг цагаригт шидэх нь техникийн чухал элемент бөгөөд янз бүрийн байрлалаас оновчтой оруулах чадварыг ....., ..... явцад олж авдаг.  
A. Хичээл, зүтгэлын  
B. Авъяас, чадварын  
C. Дасгал, сургуулилтын  
D. Онол, элементын





## ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

1. Сагсан бөмбөг үүсэх болсон шалтгааныг бичнэ үү.  
.....  
.....
2. Сагсан бөмбөгийн үндсэн техникүүдийг нэрлэнэ үү.  
A. Хамгаалалт  
B. ....  
C. ....  
D. ....
3. Дэлхийн сагсан бөмбөгийн холбооны үйл ажиллагааны чиглэл юу вэ?  
.....  
.....
4. Мэргэжлийн болон сонирхогчдын сагсан бөмбөгийн ялгааг тайлбарлан бичнэ үү.  
.....  
.....
5. Сагсан бөмбөгийн залалтын техникийг хэрхэн зөв дарааллын дагуу суралцах вэ?  
A. Үндсэн зогсолт авч залалтыг нэг гараар гүйцэтгэх  
B. ....  
C. ....  
D. ....  
E. ....
6. Шалтай ойлгож дамжуулах явцад тамирчин юуг анхаарах ёстой вэ?  
.....  
.....
7. Монголд сагсан бөмбөгийн тэмцээн анх хэдэн онд зохиогдсон бэ? Одоо хэдэн төрлийн лигийн тэмцээнүүд явагддаг вэ?  
.....  
.....
8. Бөмбөггүй тоглогчийн шилжих үндсэн арга юу вэ?  
A. Гүйлт                                  B. Үсрэлт                                  C. Залалт
9. Сагсан бөмбөгт .....-г нэг ба хоёр хөлийн түлхэлтээр хийнэ.
10. Баруун гараар шидэлт гүйцэтгэх үед зүүн гар шидэлтэд хэрхэн нөлөөлөх ёстой вэ? Шидэлтийн эсрэг талын гарны үүрэг оролцооны талаар бичнэ үү.

## СУДЛАХ АГУУЛГА

Энэ хэсэгт танхимын 7 цагийн хичээл болох Монгол орны уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлсөн хүчин зүйл, уур амьсгалын элементүүдийн газарзүйн хуваарилалт, түүний учир шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, цаг агаарын зураг, циклон ба эсрэг циклон, уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдлэг ойлголт эзэмшинэ. Агуулгын дэлгэрэнгүйг ГАЗАРЗҮЙ-VIII сурах бичгээ ашиглан судлаарай.

## ЭЗЭМШИХ ЧАДВАР

- Цаг агаарын зураг уншиж, ашиглах
- Циклон ба эсрэг циклоны шинж, агаарын чийгийн үзүүлэлтийг тодорхойлох
- Уур амьсгалд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхой газар орны жишээн дээр тодорхойлох
- Тодорхой газар орны жишээн дээр уур амьсгалын элементүүдийн газарзүйн хуваарилалт, түүний учир шалтгаан зүй тогтлыг судалж илрүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг баримтад тулгуурлан судлах

## ХӨТЛӨХ БАГШ НАРЫН МЭДЭЭЛЭЛ

Газарзүйн багш-Г.Эрдэнэсүвд

Холбогдох утас-88080425

e-mail хаяг- [erdenesuvd0425@gmail.com](mailto:erdenesuvd0425@gmail.com)

## III БҮЛЭГ: ЦАГ АГААРЫН ОНЦЛОГ

### 3.1. Цаг агаарын зураг унших

Цаг агаар ба уур амьсгал ямар ялгаатай вэ?

Тухайн цаг хугацаан дахь агаарын төлөв байдлыг цаг агаар гэнэ.

Тухайн газар орны цаг агаарын олон жилийн ерөнхий шинж төлөвийг уур амьсгал гэнэ.



Температур, даралт, салхины хурд, чиглэл зэрэг хэмжилтийн үр дүнг боловсруулан зохиосон зургийг **синоптик** буюу **цаг агаарын зураг** гэнэ.

Зураг 11. Цаг агаарын зургийн таних тэмдэг

### 3.2 Уур амьсгал бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлс

Монгол орны уур амьсгалын онцлогт ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?

Уур амьсгалд:

1. Өргөрөг
1. Нарны тусгалын өнцөг
2. Газрын орших өндөр
3. Далай тэнгист, хол ойр орших байдал




1. Нарнаас ирэх цацрагын хэмжээ өргөрөгөөс хамаарна.

Монгол орон дэлхийн хойд хагаст, дундад өргөрөгт оршдог нь сэрүүн уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлсөн.

Монгол орон  $X.042^{\circ}$ - $X.052^{\circ}$ -ийн хооронд оршдог нь


2. Дэлхийн бөмбөрцгийн хаана ямар өргөрөгт байрладаг, дэлхийн гадарга дээр тусаж буй нарны тусгал өөр өөр байдаг ба энэ нь дэлхийн хөдөлгөөнтэй холбоотой байдаг юм.



3. Манай орны нутаг дэвсгэр далайн түвшнээс дээш оршдог. Гадаргын өндөр намын зөрөө ихтэй. Гадаргын температур ба нарны цацрагын хуваарилалтад нөлөөлнө.

Өндөрлөг гадаргад оршвол сэрүүн хүйтэн, нам газар байвал дулаан.

4. Дэлхий дээр далайд гарцгүй 38 улс байдаг. Далайд ойр байвал зун нь уур амьсгал чийглэг ууршилт ихтэй, тунадас их унадаг, далайгаас хол оршдог орнуудыг бодвол сэрүүн, өвөл нь далайгаас хол оршдог газраас арай дулаахан байдаг.



### 3.2.1 Агаарын ерөнхий орчил урсгал

Уур амьсгалын эрс тэс ялгаа үүсэхэд агаарын ерөнхий орчил урсгал ба өвөл зундаа шилжин ирэх агаарын масс нөлөөлнө. Монгол орны агаарын масс:

- Арктикийн
- Сэрүүн бүсийн
- Дулаан орны

Өвөл Сибирийг бүрэлдэн тогтсон сэрүүн бүсийн эх газрын агаарын масс болон Арктикийн агаарын масс нэвтрэн ирэх үед их хүйтэн болдог. Зун өмнө зүгээс дулаан орны агаарын масс шилжин ирдэг.



Агаар орчил урсгалын дотроос манай уур амьсгалд их нөлөө үзүүлдэг нь циклон, эсрэг циклон, баруун зүгийн салхи юм.

Сэрүүн  
бүсийн  
дулаан  
агаарын  
масс


Өвөл: хүйтний эрч буурч цас орно.

Зун: Сэрүүсч, агаарын чийг нэмэгдэн  
бороо орно


### 3.3 Уур амьсгалын элементүүдийн газарзүйн хуваарилалт

Агаарын температур нь дэлхийн газар орон бүрд янз бүр байдаг. Үүнийг **температурын хуваарилалт** гэнэ. Агаарын температурын хуваарилалтад газарзүйн өргөрөг, нарны цацраг, хийн мандлын орчил урсгал, газрын хотгор гүдгэр ихээр нөлөөлнө.

Тухайн газар орны дундаж температурын хуваарилалтыг изотермын тусламжтайгаар харж болно. **Изотерм** гэдэг нь температурын ижил утгатай цэгүүдийг холбон зурсан муруй шугам юм.



1 дүгээр сарын дундаж температур



7 дугаар сарын дундаж температур

Монгол орон дэлхийн агаарын бага даралтын бүсэд оршдог боловч агаарын орчил хөдөлгөөн, туйлын фронт урагш, хойш шилжих, циклон, эсрэг циклон үүсэх, тэдгээрийн байршил, улирлын ялгаа зэргээс хамааран даралт өөрчлөгдөнө. Агаарын даралтын хуваарилалтад температур, гадарга, агаарын массын шилжилт нөлөөлдөг. Агаарын температур буурахад даралт ихсэж, температур нэмэгдэхэд даралт багасах зүй тогтолтой боловч өндөр лүү бол адилхан буурна. Өндөр ихсэхэд агаарын даралт 100 м тутамд 10гПА-аар буурна.


| Улирал | Температур                         | Даралт                           | Агаарын орчил         |
|--------|------------------------------------|----------------------------------|-----------------------|
| Зун    | Их (15°C-25°C)                     | Бага 1000-1008гПа                | Циклон ноёрхоно       |
| Намар  | Тогтворгүй, багасах<br>хандлагатай | Тогтворгүй, ихсэх<br>хандлагатай | Эсрэг циклон шилжинэ  |
| Өвөл   | Бага (-15°C-(-25°C))               | Их 1022-1054 гПа                 | Эсрэг циклон ноёрхоно |

|       |                            |       |                            |        |                       |
|-------|----------------------------|-------|----------------------------|--------|-----------------------|
| Хавар | Тогтворгүй,<br>хандлагатай | ихсэх | Тогтворгүй,<br>хандлагатай | буурах | Эсрэг циклон замхарна |
|-------|----------------------------|-------|----------------------------|--------|-----------------------|

Хүснэгт 2. Улирлын ялгаа

### Өөрийнхөө мэдлэгийг сориорой

- Хэрэв чи агаарын температурыг хэмжих хэрэгтэй болвол аль багажийг ашиглах вэ?  
А. Термометр    Б. Барометр    В. Гигрометр    Г. Флюгер    Д. Луужин
- Тохирох үгийг сонгоно уу. Циклонд төвдөө агаарын даралт ..... /их, бага/, тунадас орох нөхцөл...../сайн, муу/
- Монгол орны зонхилох салхи:  
А. Эргийн салхи    Б. Баруун хойд болон хойд зүгийн салхи    В. Фён салхи /Халуун нөөлөг салхи/
- Монгол оронд жилд дунджаар ямар хэмжээний тунадас унадаг вэ?  
А. 200-300мм    Б. 100-150мм    В. 200-220мм    Г. 500мм-ээс их
- Манай оронд аль агаарын масс нөлөөлдөггүй вэ?  
А. Арктикийн    Б. Сэрүүн бүсийн    В. Дулаан орны    Г. Экваторын
- Агаарын температурын хуваарилалтанд голлон нөлөөлдөг хүчин зүйл  
А. Газарзүйн өргөрөг    Б. Агаарын чийглэг    В. Агаарын даралт
- Уур амьсгалыг бүрдүүлэгч суурь хүчин зүйл:  
А. Газарзүйн байрлал    Б. Далайгаас алслагдсан    В. Өндөр уулсаар хүрээлэгдсэн  
Г. Өндөрлөг гадаргатай
- Монгол орны агаарын температурын хуваарилалтын зургаас:  
Жилийн дундаж температураар хамгийн дулаан газар Монгол орны аль хэсэгт байна вэ? Шалтгааныг тайлбарлана уу? Хамгийн хүйтэн газар хаана аль хэсэгт байна вэ? Шалтгааныг тайлбарлана уу?



## Assignment

## § Шугаман функц §

**Бодлого 1:**  $x$ -ээс хамаарсан  $y$ -ийн утгууд бүхий хүснэгт өгөв. Тодорхойлогдох ба утгын мужийг нь олоорой. Энэ хамаарал функц мөн үү?

|   |    |    |    |   |   |
|---|----|----|----|---|---|
| x | -4 | -1 | 0  | 2 | 5 |
| y | -1 | 4  | -1 | 9 | 6 |

**Бодлого 2:** Автобус  $60 \text{ км/ц}$  хурдтай явдаг бол түүний туулах замын урт  $s$ -ийг (км-ээр), зарцуулах хугацаа  $t$ -ээс (цагаар) хамаарсан томьёог бичээрэй. Энэ нь функц болох эсэхийг тогтоо.  $t = 5\text{ц}$  үед  $s = ?$

**Бодлого 3:** 6-ийн давталт бүх бүхэл тоог 2-т, харин 6-ийн давталт биш бүх бүхэл тоог -2-т харгалзуулав.  
 $x_1 = 25$ ,  $x_2 = -48$ ,  $x_3 = -216$  цэгүүд дээрх утгыг ол.

**Бодлого 4: Хүснэгтээр функц өгөгдөв. Графикийг нь байгуулаарай.**

|   |    |    |   |   |    |
|---|----|----|---|---|----|
| x | -5 | -3 | 0 | 2 | 4  |
| y | 6  | 4  | 2 | 0 | -2 |

**Бодлого 5: Томьёогоор функц өгөгдөв. Тодорхойлогдох мужийг нь олоорой.**

a)  $y = x^3$                       b)  $y = \frac{4}{2x-7}$

**Бодлого 6: Томьёогоор функц өгөгдөв.  $x_1, x_2, x_3$  цэгүүд дээрх утгыг олоорой.**

$$y = -3x + 4; \quad x_1 = 0; \quad x_2 = 2; \quad x_3 = -2$$

Бодлого 7:  $Ox$  тоон шулуун дээр дараах завсруудыг дүрсэл.

- a)  $x < 6$ ;    b)  $x \geq -3$ ;    c)  $-2 < x < 5$ ;    d)  $-7 \leq x \leq -4$

Бодлого 8: Нэг координатын хавтгайд  $y = kx$  шууд пропорционалын графикийг байгуул.

- a)  $k = 2$ ;                      b)  $k = -3$ ;                      c)  $k = -0.5$

Бодлого 9:  $A(p; q)$  цэгийг дайрсан  $y = kx$  функцийн пропорционалын коэффициентыг олоорой. Графикийг зур.

- a)  $p = 4, q = -1$ ;    b)  $p = -3, q = 7.5$ ;    c)  $p = -2, q = -8$

Бодлого 10:  $y = kx$  функцийн график дээр  $A$  ба  $B$  цэгүүд орших уу? Хэрэв

- a)  $k = 4, A(0; 4), B(-2; -8)$ ;  
b)  $k = -5, A(-2; 10), B(3; 15)$

Бодлого 11:  $y = f(x)$  функцийн графикийг байгуул.

- a)  $f(x) = -2x - 3$ ;    b)  $f(x) = 0.5x + 4$ ;    c)  $f(x) = 5 - 3x$

Бодлого 12: Хэсэг-хэсгээр шугаман функцийн графикийг байгуул.

- a)  $\begin{cases} x + 5, \text{хэрэв } x \geq 2; \\ -x + 1, \text{хэрэв } x < -2 \end{cases}$   
b)  $\begin{cases} -2x + 5, \text{хэрэв } x \geq 3; \\ -1, \text{хэрэв } -1 \leq x < 3; \\ 2x + 1, \text{хэрэв } x < -1 \end{cases}$



## 1. Мэдээлэн тайлбарласан эхийн утга, бүтцийг тодорхойлъё.

- Монгол гэрийн онцлог, түүнтэй холбоотой заншлын талаар ярилцаарай.
- Дараах эхийг уншихдаа цогцолборуудын дарааллыг анхаараарай.

### Монгол гэр

Гэр бол Төв Азийн нүүдэлчин ард түмний уламжлалт сууц юм. Монгол гэр 3000 орчим жилийн тэртээгээс одоогийн хэв шинж нь бүрэлдэн, амьдралын гол хэрэгцээ болсоор өнөө цагт иржээ. Хөнгөн, авсаархан, удаан эдлэгддэг, архитектурын онцгой шийдэлтэй. Геометрийн огтлолцол бүхий конус хэлбэртэй.

Эл сууц яс мод болон бүрээс гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Яс мод нь унь, тооно, хана, хаалганаас бүрддэг бол бүрээсэнд өрх, дээвэр, туурга, үүд хамаарна. Бүтцийн хэсгүүдийг нь угсрах нарийн дүрэмтэй. Үүнээс гадна хэсгүүдийг хооронд нь уяж бэхэлдэг бүдүүн, нарийн, урт, богино оосор бүчүүд чухал үүрэгтэй.

Ямар ч орон сууцны зай, багтаамж хананаас хамааралтай байдаг. Гэрийн ханыг нүүдэл хийх үед авсаархан, харин сууц болгон ашиглахад хэд дахин том болгохын тулд эвхдэг сараалж маягаар хийдэг. Гэрийн хэмжээ хананаас хамаарч янз бүр байна. Монгол гэр ихэвчлэн 4, 5, 6, 8, 10 ханатай байна. Үүнээс улбаалж, таван ханат, найман ханат, их таван ханат, бага таван ханат гэх мэтээр нэрлэдэг. XIX зууны эцэс хүртэл жирийн малчин айл дөрөв, чинээлэг баячууд тав, харин аймгийн хан, хошуу тамгын газар 8-10 ханатай гэр барьдаг байжээ.

Эрт цагт хүмүүс ширмэл эсгий хаалтыг дээш сөхөж орж гардаг байсан бол орчин үед модон хаалга хэрэглэх болжээ. Хаалга нь ханатай адил гэрийн дээд хэсгээс ирэх ачааллыг дааж байдаг, бас түүнийг байнга нээж, хааж байдаг тул бат бөх хийдэг учиртай.

Монгол гэрийн унийг тогтоож байдаг, цамхаг бүхий дугуй цагираг модыг тооно гэнэ. Гэрийн зай багтаамжийг ихэсгэх, гэрэл гэгээ оруулах, яс модны гол бүтцийг тогтооход чухал үүрэгтэй. Малчид үнээ малаа саах, хонь бэлчээх, хотлуулах зэрэгт гэрийнхээ тооноор туссан нарны тусгалаар цагийг баримжаалдаг заншилтай юм. Монголчууд тооныг гэрийн “Сүлд” хэмээн дээдэлсээр иржээ.

Тооно тэгш байх, мөн байгалийн салхи, шороо, шуурганаас болж гэр хазайх, унахаас сэргийлж, баганыг ашигладаг. Гэр барихдаа баганыг тоононд бэхэлж, босгодог. Баганын өндрөөр гэрийн өндрийг хэмжинэ. Түүнийг хаалганаас 1,5 метр өндөр байхаар тооцоолж хийнэ.

Гэрийн доторх нарны цацрагийг бэлгэддэг яс мод бол унь. Энэ нь хана болон тооныг холбох, бүрээсийг тогтоон барих үүрэгтэй. Монголчуудын дунд шулуун болон махир үзүүртэй хоёр янзын унь уламжлагдан иржээ. Таван ханатай гэрийн унь 2-2,5 метр урт байдаг бол дөрвөн ханатай гэрийн унь 1,5-2 метр урттай байдаг.



Гэрийн бүрээсийг хонины ноосоор хийж, ямааны тосоор тослон, борооны ус нэвчихээргүй болгодог. Өнгийг нь цайруулахын тулд эсгийг ясны гурил, шохойгоор өнгөлнө. Эсгийгээр өрх, дээвэр, туурга, үүд зэргийг хийх бөгөөд энэ нь дулааныг хамгийн бага алддаг бүрээс юм.


Тоонон дээгүүр бүтээж, нар, салхи, цас, бороо, шороо, хурц гэрэл гэгээнээс хамгаалах, мөн гэрт тусах нарны гэрэл гэгээг тохируулах үүрэгтэй бүрээс бол өрх. Харин гал голомт арвай будаа шиг арвижин дэлгэрч, цэвэр тунгалаг байхыг бэлгэддэг оосор бол чагтага. Тоононы чанх голоос чагтагыг уяж, сул үзүүрийг унинд хавчуулна. Салхи ихтэй үед чагтагыг буулгаж, үзүүрт нь хүнд юм уях буюу газарт гадаслах замаар гэрийг хөдөлгөөнгүй болгодог.

Гэрийн модны хээ угалз, чимэг, өнгө будаг эрт үеэс уламжлалтай. Монголчууд улаан, улбар өнгө бол нарны дулаан орчныг бүрдүүлдэг гэж үздэг учир тооно, унь, багана, хаалгаа ийм өнгөөр буддаг. Харин нарны гэрлийг гэрийн дотор хэт хурц тусахаас сэргийлж, унины цээжийг ногоон өнгөөр тайвшруулан буддаг болжээ.

Гэрийн доторх зайг хоймор тал, үүдэн тал, гэрийн эзэгтэйн тал, гэрийн эзний тал гэж ялгах нь зай талбайн журмыг тогтоосон хэв ёс байжээ. Монголчууд гэрийнхээ гол дунд гал голомт буюу тулгаа байрлуулдаг. Түүнийг тойрсон орон зайн баруун талд эрэгтэй хүний эд зүйл, зүүн талд эмэгтэй хүний эд зүйлийг байрлуулдгаас болж эзэгтэй тал, эрэгтэй тал хэмээх болсон ажээ. Мөн гэрийн доторх орон зайг 12 жилээр хуваан нэрлэх, зүг чиг заах, өнгөөр ялган, гэрийн наран цагийн хуваарийг бий болгосон нь гэртэй холбоотой ардын мэдлэгийн нэгэн өв билээ.

Гэр бол барих, буулгах, зөөж тээвэрлэх, үйлдвэрлэх арга технологи нь хялбар, багтаамжийн хувьд хамгийн оновчтой, агаарын болон дулааны солилцоог амархан зохицуулах бололцоотой сууц бөгөөд нүүдэлчин монголчуудын бүтээсэн гайхамшигт эдийн соёлын нэг юм.

(<https://mn.wikipedia.org/wiki/>)





а. Дараах асуултад хариулж, бичээрэй.

- Монгол гэрийн түүх хэдий үеэс эхэлдэг вэ?
- Монгол гэр конус хэлбэртэй байдгийн давуу талуудыг мэдэж, мэдээлэл солилцоорой.
- Монгол гэр бол нүүдэлчин монголчуудын бүтээсэн эдийн соёлын нэг. Суурин соёл иргэншил рүү шилжиж буй өнөө үед хэр үнэ цэн, ач холбогдолтой вэ? Саналаа солилцоорой.
- Монгол гэрийн бүрдэл хэсгүүдийн нэрийг зургийн хажууд бичээрэй.

б. Монгол гэрийн бүрдэл хэсэг, тэдгээрийн үүргийг ялгаад, хүснэгтээр харуулаарай.

в. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг өөр өнгөөр ялган тэмдэглээрэй.

г. Эхийн бүтцийг шинжлэхдээ дараах хүснэгтийн дагуу ажиллаарай.

- Аль хэсэгт ерөнхий танилцуулга, аль хэсэгт нэмэн дэлгэрүүлж, сэдвийг дэмжсэн санаа, аль хэсэгт дүгнэлт байгааг тэмдэглээрэй.

| Бүтцийн хэсэг | Цогцолборын дугаар | Цогцолбор тус бүрд юуны (сэдэв) тухай өгүүлсэн байна вэ? |
|---------------|--------------------|----------------------------------------------------------|
| Эхлэл         |                    |                                                          |
| Гол хэсэг     |                    |                                                          |
| Төгсгөл хэсэг |                    |                                                          |

д. Дараах асуултын дагуу ярилцаад, эхийн бүтэц ба утгын холбоо хамаарлыг бүдүүвчээр харуулаарай.

- Аль нь хамгийн ерөнхий сэдэв бэ? Яагаад?
- Дэд сэдвүүд нь юу юу вэ? Яагаад ингэж үзсэн бэ?
- Дүгнэлт өгсөн хэсэг байна уу? Түүнийг яаж таньсан бэ?

## 2. Мэдээлэн тайлбарласан эхийг задлан шинжилье.

а. Өгүүлэгч “Монгол гэр” эхийг ямар зорилгоор бичсэнийг тодорхойлоорой.

б. Тоочин бичих онцлогийг дараах асуултын дагуу шинжлээрэй.

- Ямар үгийг олон удаа хэрэглэсэн байна вэ?


| Үгийн аймаг           | Жишээ | Ямар утгаар орж байна вэ? |
|-----------------------|-------|---------------------------|
| Жинхэнэ нэр           |       | Юмыг заан нэрлэсэн.       |
| Тэмдэг нэр            |       |                           |
| Үйл үг                |       |                           |
| Тооны нэр             |       |                           |
| Орон цагийн нэр       |       |                           |
| Дүрслэх ба дуурайх үг |       |                           |

- Үгийн аймаг тус бүрийн хэл зүйн хэлбэржилт нь ижил байна уу? Ялгаатай байна уу? Ажиглаарай.
- Таслалыг олон удаа хэрэглэсний учир юу вэ? Тайлбарлаарай.

в. Үгийн утгыг шинжлээрэй. Дараах загварын дагуу ажиллана уу.

| Үг хэллэг                        | Байна (+)<br>Байхгүй (-) | Жишээ | Шалтгаан |
|----------------------------------|--------------------------|-------|----------|
| Далд утгатай үг хэллэг           |                          |       |          |
| Шууд утгатай үг хэллэг           |                          |       |          |
| Мэргэжлийн болон нэр томьёоны үг |                          |       |          |
| Уран дүрслэл                     |                          |       |          |

г. Баг болж, өгүүлбэрт шинжилгээ хийгээрэй. Эхлээд өгүүлбэрүүдээ дугаарла. Дараа нь бүдүүвчийн дагуу хувааж ажиллаад, нэгтгэнэ үү.



д. Өгүүлбэр, цогцолборуудаа юугаар холбож, яаж дараалуулсныг тодорхойлоорой.


- Дараах хүснэгтийн дагуу ажиллана уу. Жишээ нь:

| Цогцолборын дугаар | Цогцолборын доторх өгүүлбэрийг юугаар холбосон байна вэ?                                                     | Цогцолборуудыг юугаар холбосон байна вэ? |
|--------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|
| 4                  | ба - зэрэгцүүлэн холбох үг<br>харин - зэрэгцүүлэн холбох үг<br>тулд - шалтгааны утгат угсруулан холбох үгээр |                                          |


- Дээрх хүснэгтийг сайн ажигла. Зэрэгцүүлэн болон угсруулан холбох хэрэглүүрийн алийг нь олон хэрэглэсэн байна вэ? Учрыг тайлбарлаарай.

е. Дараах бүдүүвчийг ажиглаад, цогцолборуудыг ингэж дараалуулсны учрыг тайлбарлаарай. Эдгээрийн байрыг сольж болох уу? Яагаад?





ё. Эхэд дараах ойлголтууд байгаа эсэхийг шинжлээд, байгаа, байхгүйн учрыг бичигчийн зорилготой холбон тайлбарлаарай.



### 3. Баримтад шинжилгээ хийе.

- Эх дэх ерөнхий мэдээлэл болон баримтыг өөр өнгөөр ялгаж будаарай.
- Ерөнхий мэдээлэл, баримт хоёр тохирч байгаа эсэхэд шинжилгээ хийнэ үү. Дараах хүснэгтийн дагуу ажиллаарай.


| Цогцолборын дугаар | Ерөнхий мэдээлэл | Чухал баримт |
|--------------------|------------------|--------------|
|                    |                  |              |



## Амралтын даалгавар

1. Scratch програмын дараах 3 дасгалыг хийгээрэй. Даалгаварын үр дүн oas.homework8@gmail.com хаягаар явуулаарай.
2. Даалгавар2. 1 сарын 22нд ирэхдээ бие даалтаа хэвлээд нуруулдаад авчрах

<https://as-prod.asyncgw.teams.microsoft.com/v1/objects/0-sa-d2-42fd2de28c04c3a64ce8dac027b10411/views/imgo>



## 8-Р АНГИЙН ДААЛГАВАР

### 1-Р ӨДӨР

#### 1. Заполни таблицу/Хүснэгтийг бөглөнө үү

| зима    | весна  | лето   | осень    |
|---------|--------|--------|----------|
| декабрь |        |        | сентябрь |
|         | апрель |        |          |
|         |        | август |          |

#### 2. Напишите вопрос/асуулт бичнэ үү

1. Сейчас осень. \_\_\_\_\_ ?
2. Сейчас ноябрь. \_\_\_\_\_ ?
3. В школе мы можем увидеть книги. \_\_\_\_\_ ?
4. Я рисую машину. \_\_\_\_\_ ?
5. Максим пришел из школы. \_\_\_\_\_ ?
6. Я иду в магазин. \_\_\_\_\_ ?
7. Музей слева от библиотеки. \_\_\_\_\_ ?
8. Мама купила подарок для сестры. \_\_\_\_\_ ?
9. Папа приехал из города. \_\_\_\_\_ ?
10. Книга стоит 150 рублей. \_\_\_\_\_ ?

### 2-Р ӨДӨР

#### 1. Напиши цифры/тоонуудыг бичнэ үү

двести \_\_\_\_\_,  
сто тридцать пять \_\_\_\_\_,  
двадцать шесть \_\_\_\_\_,  
семьдесят восемь \_\_\_\_\_,  
сорок четыре \_\_\_\_\_,  
пятьдесят девять \_\_\_\_\_,  
девять \_\_\_\_\_,  
девяносто семь \_\_\_\_\_,  
сто восемьдесят \_\_\_\_\_.

#### 2. Переведите на монгольский язык/ монгол хэл рүү орчуулна уу

1. Старинный фонтан сделан из камня. \_\_\_\_\_.
2. Старая машина сделана из металла. \_\_\_\_\_.
3. Мамина расчёска сделана из пластмассы. \_\_\_\_\_.
4. Украшения сделаны из дерева и стекла. \_\_\_\_\_.
5. Москва – это большой и красивый город. Москва – это столица России. \_\_\_\_\_.

#### 3. Ответьте на вопросы по-русски/ асуултанд орос хэлээр хариулна уу

1. Твоя мама говорит по-русски? \_\_\_\_\_
2. Какая сегодня погода? \_\_\_\_\_
3. Когда у тебя день рождения? \_\_\_\_\_
4. Когда мы говорим «Доброе утро?» \_\_\_\_\_
5. Когда мы носим тёплую одежду? \_\_\_\_\_
6. Какое сейчас время года? \_\_\_\_\_
7. Какой сейчас месяц? \_\_\_\_\_

### 3-Р ӨДӨР

#### 1. Переведите/орчуулна уу

1. Миний төрсөн өдөр наймдугаар сард. \_\_\_\_\_
2. Миний муур шөнө зугаалах дуртай. \_\_\_\_\_
3. "Өглөөний мэнд" гэж бид өглөө хэлдэг. \_\_\_\_\_
4. "Өдрийн мэнд" гэж бид өдөр хэлдэг. \_\_\_\_\_

#### 2. Напишите названия месяцев по-русски/Саруудын нэрийг оросоор бичнэ үү

---

---





# VIII АНГИ

ДӨРӨВДҮГЭЭР ДЭВТЭР

# ТҮҮХ

(СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХӨТӨЧ)

## **IV ХЭСЭГ**

### **СУДЛАХ АГУУЛГА**

Энэ хэсэгт танхимын 10 цагийн хичээл болох “Газарзүйн их нээлт, колоничлолын эхлэл”, “Шашны шинэтгэл”, “Сэргэн мандалт ба хүмүүнлэг үзэл”, “Соён гэгээрлийн хөдөлгөөн”, “Капитализмын үүсэл, шинж онцлог” агуулгуудыг судлах болно. Агуулгын дэлгэрэнгүйг ТҮҮХ-VIII сурах бичгээ ашиглан судлаарай.

### **ЭЗЭМШИХ ЧАДВАР**

- Газарзүйн их нээлт, колоничлолын эхлэлийн үр дагаврыг дүгнэн ярилцах
- Шашны шинэтгэл болон Сэргэн мандалт ба хүмүүнлэг үзлийн мөн чанарын тухай ойлголттой болох
- Капитализмын үүсэл, шинж онцлогт харьцуулалт хийх

### **ХӨТЛӨХ БАГШ НАРЫН МЭДЭЭЛЭЛ**

Нийгэм судлалын багш- **М.Батмөнх**      Түүхийн багш- **Х. Түвшинбаяр**

Холбогдох утас-**88065498**

Холбогдох утас-**95972281**

e-mail хаяг- [mbatmunkh0809@gmail.com](mailto:mbatmunkh0809@gmail.com)

e-mail [хаяг-tuvshinbayar.pain@gmail.com](mailto:хаяг-tuvshinbayar.pain@gmail.com)

## II БҮЛЭГ: ДЭЛХИЙН ТҮҮХИЙН ШИНЭ ҮЕ ЭХЭЛЛЭЭ

### Газарзүйн их нээлт, колоничлолын эхлэл

Газарзүйн их нээлт гэж, 15-18-р зууны үед барууны соёл иргэншил шинэ газар орон нээж, өөрийн нөлөөгөө тогтоохоор өрсөлдөж байсан Европын түүхийн үе, тэр үед хийгдсэн шинэ нээлтүүдийг хэлдэг. Газарзүйн их нээлт дэлхийн түүхийн шинэ үе эхлэлийг тавьж, олон түүхэн өөрчлөлтийг араасаа дагуулсан юм. Тухайн үеийн их нээлтүүд нь даяарчлал, колоничлолыг үндсийг тавьсан гэж үзэх нь бий. Их нээлтүүдийн үр дүнд европчуудын танилцсан шинэ газар орны ихэнх нь тухайн үедээ аль хэдийн өөрийн гэсэн оршин суугчидтай, соёл иргэншилтэй байсан бөгөөд тэдгээр уугуул иргэдийн хувьд булаан эзлэгчдийн эрин үе байсан билээ.

Энэ үе нь Мадейрын арлууд, Азорын арлууд гэх Атлантын далайн олтригууд болон Африкийн эрэг, улмаар 1498 онд Энэтхэг хүрэх усан замыг нээсэн португалчуудын нээлт, мөн Кастилийн вант улсын нэрийн өмнөөс 1492-1502 Атлантын далайг хөндлөн гулд аялсан Христофер Колумбын аяллууд, 1519-1522 онд дэлхийг анх удаа тойрсон Фернан Магелланы аяллаар хүчээ авсан түүхтэй. Ийнхүү шинэ газар орныг нээх хүсэлдээ автсан аялагчид хэдэн зууны туршид Атлант, Энэтхэгийн болон Номхон далайгаар хөвцгөөж, Америк, Ази, Африк, Австрали тивээр хөшилдөж байсан бөгөөд 20-р зуунд хойд туйлын бүс рүү ороод өндөрлөжээ.

Эдгээр нь олон улсын худалдаа, колонийн эзэнт гүрнүүдийн мандан бадарсан үе бөгөөд Хуучин ертөнц (Европ, Ази, Африк) болон Шинэ ертөнц (Америк, Австрали)-ийн хооронд ургамал, амьтан, хоол хүнс, хүн ам (боолуудыг оролцуулаад), халдварт өвчин, соёлын солилцоо явагдсан юм. Тэрхүү солилцоог Колумбын солилцоо гэдэг. Энэ нь хүний түүхэн дэх хамгийн том нөлөө үзүүлсэн экологи, хөдөө аж ахуй, соёлын даяарчлалын эрин байлаа. Мөн Христийн шашин дэлхийн өнцөг булан бүрт хүрч, дэлхийн хамгийн том шашин болоход их нээлтүүд чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

### Шашны шинэтгэл

Шашны шинэтгэл нь 16-р зуунаас эхэлсэн бөгөөд энэ нь Папын засаглалыг эсэргүүцсэн. Учир нь Папын засаг захиргаа нь Библийн үнэнээс гажиж эхэлсэн хэмээн шинэчлэгчид үзсэн байна. Шашны шинэтгэлийн хувьд хүмүүс гурван аргаар тэмцэж байсан ба энэ зэвсэгт тэмцэл, зөвхөн Библийн сургаал номлолыг дагах байдлаар, люуны дэвшлийн хүрээнд зэрэг байлаа. 16-р зууны үед Мартин Лютер, дараа нь Жон Калвин гэдэг санваартнуудын удирдлага дор Реформацийн хөдөлгөөн буюу Шашны шинэтгэл гүнзгийрсэн. Мартин Лютерийг Протестант урсгалыг хамгийн анх үүсгэн байгуулагч гэж үздэг. Хамгийн чухал шинэчлэлүүдийг тэрээр хийсэн бөгөөд хүмүүс латин хэлээрх Библи буюу Вулгат талаар Ромын Католикчууд юу яриад байгааг нь ойлгохгүй байсан тул санваартнууд дураараа хууль дүрэм гаргадаг байдлыг Мартин Лютер Библийг Герман хэл рүү хөрвүүлснээр илчилсэн байна. Тэрээр Брандбургийн их сургуулийн профессор байсан ба мөн католик шашны санваартан хүн байсан. Тэр 1517 оны 5 сард Брандбург сүмийн хаалган дээр 95 сэдэвтэй тунхаглал Брандбургийн Альбертэд хандаж гаргасан. Энэ тунхаглалд



Христийн чуулганууд Ромын Папын захиргаанаас гарах.

Хүн гагцхүү итгэлээр тэнгэр бурхны нигүүлслээр аврагдана.

Европын соёлт орнууд Ариун Библийг үндэстнийхээ хэлээр орчуулж өөрийнхөө хэлээр сурах ёстой зэрэг байлаа.

Уг шашны шинэтгэл хийгчдийг тухай үед "Тэрс үзэлтнүүд" гэж нэрлэж байсан бөгөөд энэ нь латин хэлээр Протестант гэсэн үг юм. Реформацийн хөдөлгөөн улам ширүүссээр 1525 онд Тариачны бослого, түүнчлэн Гэгээн Сиэгэ гэгч Ромын Папын туслах, удирдагч зэрэг олон хүмүүсийн дэмжлэгээр Лютерийн тунхаглалууд тархсаар байлаа. Энэ бүхэн оргилдоо хүрэхэд Протестант гэх шинэ Христ Итгэлийн урсгал бий болжээ.

### **Сэргэн мандалт ба хүмүүнлэг үзэл**

Сэргэн мандалт нь орчин үеийн шинжлэх ухааны олон салбарын үндэс суурийг тавьжээ. Шинжлэх ухааны хөгжил нь Европ тивийн төдийгүй хүн төрөлхтний иргэншилд хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Энэ үеийн соёлын гол төвүүд нь Флоренц, Милан, Венец зэрэг Италийн цэцэглэн хөгжиж буй хотууд байжээ. Эдгээр хотод худалдаа, банк, үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байв. Тухайн үеийн сурвалжит гэр бүлүүд болох Флоренц хотын Медичи, Милан хотын Сфорзагийн гэр бүлийнхний өөрсдийн нэр төрийг өргөх гэж соёлын тансаг зүйлсэд мөнгийг чөлөөтэй зарцуулж байлаа. Түүнчлэн Унгарын Маттиас Корвин, Францын 1 Франсис зэрэг баян хаад сүр хүчээ сурталчлах үүднээс уран бүтээлч, оюунлаг хүмүүсийг ихээр дэмжиж байв. Үүний үр дүнд шинжлэх ухаан, урлаг соёлын олон шинэ нээлт бүтээл гарчээ.

Сэргэн мандалтын үеийн онцлог шинж чанар нь соёл урлагийн нийгмийн шинж ба түүний Антропоцентризм буюу “ертөнцийн төвийг хүн гэж үздэг” сургаал юм. Тухайлбал энэ үед хамгийн түрүүнд хүн, хүний үйл ажиллагааг онцлон судалсанд оршино.

### **Соён гэгээрлийн хөдөлгөөн**

XVIII зууны үед баруун европын түүхэнд соён гэгээрүүлчидийн хэмээн нэрлэгддэг нэгэн онцгой үе гарч ирсэн юм. Соён гэгээрүүлэх үзэл санаа анх XVII зууны үед үүссэн бөгөөд үүнийг санаачлагч нь Английн философич Дж.Локк (1632-1704) байлаа. Гэхдээ энэ үзэл санаа дараагийн зуунд л цэцэглэн хөгжсөн юм.

Руссо Жан Жак (1712-1778) Швейцар гаралтай францын философич, улс төрийн онолч Ж.Ж.Руссо 1712 онд Женев хотноо мэндэлжээ. Францын соён гэгээрлийн үеийн агуу сэтгэгчдийн нэгээр барахгүй түүний сэтгэлгээ нь Кант, Гёте, Толстой болон францын бусад хувьсгалчдад ихэд нөлөөлсөн байна. Түүний хамгийн алдар цуутай онол нь жам ёсны эрхийн сургааль юм. “Нийгмийн гэрээний тухай буюу улс төрийн эрхийн зарчмууд”, “Соёлын шүүмжлэлийн бичиг”, “Төр ба нийгэм”, “Хүмүүсийн дунд тэгш бус байдал үүссэн тухай” зэрэг олон бүтээлтэй.

Тэдний үзэж байгаагаар шинэ нийгмийг байгуулах үндсэн хэрэглэгдэхүүн нь хүнийг гэгээрүүлэх хүмүүжүүлэх асуудал юм. Гэрэлт ирээдүйг амжилттай бүтээн байгуулахад оюун ухаан шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Соён гэгээрүүлэгчид хүний тухай, хүний эрх, эрх чөлөөний тухай нэгдмэл үзэл онолыг боловсруулсан юм. Энэ үед шашин хурц шүүмжлэлд

өртсөн юм. Шашины эсрэг хамгийн шийдвэртэй тэмцэж байсан хүн бол Францын их соён гэгээрүүлэгч Вольтер байлаа.

### Капитализмын үүсэл, шинж, онцлог

XV зуунд алс аялах чадвартай усан онгоц бүтээж Америк тивийг нээснээр капитализм үүсэв. Эзэнт гүрнүүд, тэднийг санхүүжүүлэх худалдааны төвүүд далайн чанадад байгуулагдсан нь дэлхийн худалдаанд түлхэц өгчээ. Капитализм XII зуунаас Европын эдийн засаг, улс төр, соёл, бүр дайны үйл хэрэгт ч нөлөөлөх болов.

Дорноос Европд оруулж байсан барааны үнэ өртөг аяллын зардлаа хэд нугалахаар өндөр байв. Тиймээс худалдаанд хэдийгээр эрсдэл ихтэй ч хөрөнгө оруулалт хийх нь ашигтай байлаа. Шаардлагатай хөрөнгө босгохын тулд худалдаачид хамтарсан компани байгуулах болов. Уг компани нь тодорхой хугацааны дараа хөрөнгө хуримтлуулж эрэлт ихтэй зах зээл эзэмшиж урт хугацаагаар оршин тогтнох болсон юм. Тэд хилийн чанадад худалдааны давуу эрх эдэлж байв.

XVI зууны үеэс Англид аж үйлдвэрийн анхдагч хэлбэр болох мануфактурууд бий болсон юм. Үйлдвэрийн эзэд ажилчдын хөлс хүчээр асар их ашиг олох болов. Жишээ нь: Зүүний цех өдөрт 20 зүү гаргадаг байсан бол мануфактурын зохион байгуулалтад орсноор өдөрт 1800 зүү үйлдвэрлэх болжээ. Хөдөө аж ахуйн зарим салбарт аж ахуйгаа эрхлэн хөтлөх шинэ арга нэвтэрч эхлэв. Энэ нь эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд нөлөөлөв. Урьд нь тариалж байсан газар бэлчээр дээр үйлдвэрийн газрууд байгуулагдаж, хотын хүн ам хурдацтай өсөх болжээ.

## ДАСГАЛ ДААЛГАВАР

1. Колумбын солилцоо гэж юу вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

2. Сэргэн мандалтын үед ямар өөрчлөлтүүд гарч байсан бэ?

.....

.....

.....

.....

.....

.....

3. Шашин хэрхэн яаж хувьсан өөрчлөгдсөн бэ?

.....

.....

.....

.....

.....

.....

4. Газарзүйн их нээлтийн үр дагавар нь юу байсан бэ?

.....

.....

.....

.....

.....

.....

5. Мануфактур бий болсноор ямар дэвшилүүд бий болсон бэ?

.....

.....

.....

.....

.....

.....

## ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

1. Атлантын далайг 1492-1502 онд хөндлөн гулд аялсан далайчныг нэрлэнэ үү  
А. Фернан Магеллан В. Христофер Колумб С. Васко да Гама D. Лоренцо Медичи
2. Дэлхийг анх удаа тойрсон далайчныг дугуйлна уу  
А. Фернан Магеллан В. Христофер Колумб С. Васко да Гама D. Лоренцо Медичи
3. Шашны шинэтгэл хэддүгээр зуунаас эхэлсэн бэ?  
А. XV В. XVI С. XVII D. XVIII
4. Протестант урсгалыг хэн үүсгэн байгуулсан бэ?  
А. Мартин Лютер В. Ромын пап X Лео С. Жан Кальвин D. Иохан Тецель
5. Унгарын Маттиас Корвин, Францын I Франсис зэрэг баян хаад сүр хүчээ сурталчлах үүднээс уран бүтээлч, оюунлаг хүмүүсийг ихээр дэмжиж байв. Үүний үр дүнд ямар салбарууд хөгжсөн бэ?  
А. Шинжлэх ухаан В. Урлаг С. Соёл D. Дээрх салбарууд бүгд хөгжсөн .
6. 1517 оны 5 сард Брандбург сүмийн хаалган дээр юу наасан бэ?  
А. 90 сэдэвтэй тунхаглал В. 95 өгүүлбэр бүхий зар С. 95 сэдэвтэй тунхаглал
7. “Төр ба нийгэм”, “Хүмүүсийн дунд тэгш бус байдал үүссэн тухай” зэрэг бүтээлүүдийг хэн туурвисан бэ?  
А. Дж. Локк В. Ж. Ж. Руссо С. Шарль Монтескье D. Т. Гоббс
8. Соён гэгээрүүлэх үзэл санааг хэн анх санаачилсан бэ?  
А. Дж. Локк В. Ж. Ж. Руссо С. Шарль Монтескье D. Т. Гоббс
9. Шашины эсрэг хамгийн шийдвэртэй тэмцэж байсан Францын их соён гэгээрүүлэгчийг нэрлэнэ үү  
А. Мартин Лютер В. Ромын пап X Лео С. Жан Кальвин D. Вольтер
10. Капитализм XII зуунаас ..... тивийн эдийн засаг, улс төр, соёл, бүр дайны үйл хэрэгт ч нөлөөлөх болов.  
А. Ази В. Америк С. Европ D. Африк